



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

198 I оны 10 дугаар
сарын 22 ны өдөр

Дугаар 254

Улаанбаатар
хот

НӨӨЦ БОЛОЛЦОО АШИГЛАХ БРИГАД
АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 104-р тогтоолыг үндэслэн Дарь-Эхийн овоонд байгуулсан хаягдал ялгаж ашиглах бригад нь байгуулагдан жилд 27,5-35,6 мянган төгрөгийн орлого оруулж, 3,0-3,3 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байгааг тэмдэглээд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.Багануурын районы хогийн цэгээс яс, төмөр, гууль, зэс, шил ялган цуглуулж улсын бэлтгэлд тушаах 3 хүнтэй бригадыг аж ахуйн тооцоон дээр туршлагын журмаар 1981 оны II-р сарын I-нээс I жилийн хугацаагаар түр байгуудж ажиллахыг Багануурын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаанд зөвшөөрсүгэй.

2.Ажиллах орон тоог I-р хавсралтаар орлого, зарлагын тооцоог 2-р хавсралтаар баталсугай.

3.Хаягдал цуглуулж бэлтгэл конторт тушаах, тэдний ажилд байнга хяналт тавьж ажиллахыг Багануурын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Пүрэвдорж/-д даалгасугай.

4.Цаашид Хамба Дарь-Эхийн овоонд байнгын бригадуудын ажиллах нөхцлийг сайжруулан, гар ажиллагааг хөнгөвчлөх үндсэн дээр 1982 оны I-р улиралд багтааж Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хороонд асуудал оруулж орон тоо, цалинг шийдвэрлүүлэхийг Хот тохижуулах газар /н.Бадрах/-т үүрэг болгосугай.

ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *[Signature]* С.МОНХЖАРГАЛ

ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА *[Signature]* Ч.ЖАМБАЛ

